

МЭДЭЭ

**МОНГОЛЫН ГЕОЛОГИЙН СУДАЛГААНД
МУИС-ИЙН ГЕОЛОГИЙН САЛБАРЫН
ТӨГСӨГЧДИЙН ОРУУЛСАН
ХУВЬ НЭМЭР**

С.ДАШДАВАА, С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улсын Их Сургууль

1960 онд Монгол Улсын Геологийн салбарыг байгуулж, Газарзүйн тэнхимд 1 багштайгаар (монголын анхны ахмад геологич доктор Ж.Дүгэрсүрэн) хичээл сургалтын ажил эхэлжээ. Энэ ондоо газарзүйн 3-р ангиас 13 оюутныг салган геологийн 3-р анги болгож, геологийн 1-р ангид 39 оюутныг шинээр элсүүлж, 52 оюутантай, 1 багштайгаар байгуулсан юм. 1961 онд цагийн багшаар ажиллаж байсан Р.Барсболд, Ж.Лхамсүрэн нарыг үндсэн багшаар авч ЗХУ-аас уригдан ирсэн мэргэжилтэн багш Ю.Ф.Пекун, К.М.Малкова нар, багшаар доктор Ж.Дүгэрсүрэн тэнхимийн эрхлэгчээр томилогдож, 5 багштай Геологийн тэнхимийг байгуулж, биеэ даасан салбар болж хөгжсөн. 1961 оноос жил бүр 50 оюутныг элсүүлэн авч 5 жилийн дотор оюутны тоо эрс өсөж, түүнийг дагаж багш олноор шаардагдаж эхэлсэн энэ үед академич Б.Лувсанданзан, Р.Барсболд, Д.Дашзэвэг, О.Төмөртогоо, профессор Ж.Лхамсүрэн, С.Дашдаваа, О.Гэрэл, Н.Батсүх, Б.Ишмэнд, дэд профессор В.Балжинням, М.Жамсран, Я.Болд, Ж.Ган-Очир, П.Дугараа, Ч.Минжин, Я.Гомбосүрэн, П.Хосбаяр, Г.Лханаасүрэн, инженер М.Дамбажамц, С.Дэмбэрэлдорж, Ж.Цэвээнсүрэн, Д.Амар, Зөвлөлтийн мэргэжилтэн багш В.К.Куликовский, В.К. Финашин, В.Д.Соболев, К.Л.Попровко, Б.Б.Кудряшов, П.Ф.Пальянов, В.В. Кожевников, В.А.Наумов, В.В. Большаков, И.Е. Лескевич нар уригдан ирж, үндэсний геологичдийг бэлтгэх эхний үед үнэтэй

хувь нэмэр оруулан ажиллаж байсан. Геологийн мэргэжилтэн бэлтгэх анхны жилүүдэд багшилж байсан манай үндэсний геологичид одоо Монголын геологийн нэртэй эрдэмтэд болон өссөн байна. Нэгэн баримтыг дурдахад одоо манай эрдмийн зэрэг хамгаалсан 50 гаруй геологичид бараг бүгд үндэсний геологичдийг бэлтгэх ажилд оролцсон юм. 1-2-р зурагт Монголын Геологийн шинжлэх ухааныг өнөө үеийн шатанд хүртэл хөгжүүлж ирсэн манай нэрт эрдэмтэд сургалтанд оролцож байсныг харуулав. Манай геологичдийн дундаас төрсөн академич-4, профессор 5, шинжлэх ухааны доктор 12, дэд профессор 9 бүгд хичээл зааж байжээ. Боловсролын доктор зэрэгтэй 50 хүнээс 45 нь сургалтын ажилд оролцож хичээл зааж байжээ. Үүнээс үзэхэд эх орондоо үндэсний геологичдийг бэлтгэхэд хичээл заалгуулахаар сонгож авч байсан мэргэжилтэнгүүд манай геологийн салбарын нэртэй эрдэмтэд болсон байна.

Геологийн салбарын анхны төгсөлт 1963 онд болж 13 инженер геологич бэлтгэгдэн гарлаа. Хоёрдох төгсөлт нь 1965 онд болж 19 инженер төгсч түүнээс хойш өнөөг хүртэл тасралтгүй төгсөлт явагдаж, энэ хугацаанд 1000 гаруй геологич инженерүүд бэлтгэгдэн гарчээ. Манай улсын хөгжлийн дагуу 60, 70, 80-иад онуудад геологи шинжилгээний ажлын хэмжээ эрс нэмэгдэж түүнийг дагаж мэргэжилтэй боловсон хүчний шаардлага улам ихээр нэмэгдэж, энэ

ажлыг хэрэгжүүлэхэд үндэсний боловсон хүчний үүрэг томоохон ач холбогдолтой байлаа. Үндэсний геологичдийн тоо нэмэгдэх тутам манай оронд ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтний тоо буурч яваандаа монголын геологийн судалгааны ажлыг үндэсний геологичид дангаараа хийдэг болжээ. Энэ нь боловсон хүчний талаар богино хугацаанд болсон ихээхэн амжилт юмаа. Манай орны геологийн судалгааны үе шатны шаардлагын дагуу эхний жилүүдэд эх орныхоо газар нутгийг 1:1 000 000, 1:500 000, 1:200 000-ын масштабын геологийн зургаар бүрэн нэн чухал зорилт тавигдаж байсан. Энэ зураглалын ажлыг газар дээр нь гүйцэтгэгч геологичид бол тус сургуулийг төгссөн эхний төгсөлтийн ахмад геологичид байлаа. Эдгээр судалгааны ажлыг зохих хугацаанд нь эрчимтэй хийсний үр дүнд манай орны бүх нутгийн 96 орчим хувийг 1:200 000 масштабын геологийн зураглалын ажлаар бүрсэн байна. Энэ 1:200 000 масштабын зураглалын ажлыг ид явж байх үед орон нутагт ажиллаж байгаа геологийн экспедиц удирдах газар, түүний харъяа анги, отрядуудын дарга, ерөнхий инженер, ерөнхий геологи, ахлах геологичдийн ажлыг тус сургуулийг төгссөн геологичид бүрэн хариуцан хийж байлаа. Олон жил 1:200 000 масштабын зураглалын ажлыг чанарын өндөр хэмжээнд хийж, эх орныхоо геологийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан нэр төртэй геологичид олон байна. Үүний дотроос аж үйлдвэрийн гавъяат ажилтан геологич Д.Тогтох, геологич Д.Санжаадорж, Х.Дадилхан, Ц.Баатар, Ш.Лхүндэв, Ч.Цэдэнбал, Д.Жагварал, И.Ниндэвгомбо нарын олон геологичдийг нэрлэж болох байна (зураг 3). Ашигт малтмалын ордын эрэл зураглалын ажлыг эрчимтэй хийх шаардлагын үүднээс чухал шаардлагатай сонгосон газруудад 1:50 000 масштабын эрэл зураглалын ажлыг хийж, ордын үнэлгээ өгөх ажлыг олон

жил чанар сайтай хийж, манай оронд ашиглагдаж байгаа ашигт малтмалын төрөл бүрийн ордыг нээж илрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан геологич Д.Баадай, Ш.Баасандорж, Д.Пүрэвдорж, Ц.Цэдэн, Т.Намсрай, Л.Борис, Т.Сэнгэдорж, П.Шаандар, Л.Базарсад нарын олон геологичид энэ ажилд идэвхитэй оролцож байлаа.

Энэ үеийн геологийн судалгаагаар олсон ашигт малтмалын орд илрэлүүд дээр эрэл хайгуулын ажил хийж, түүний нөөцийг бодож ашиглалтанд хүлээлгэж өгөх чухал шаардлагатай ажлуудад манай төгсөгчид олон жил үр бүтээлтэй ажиллаж, олон тооны орд газрын эрэл хайгуулын ажлыг дуусгаж, ашиглалтанд өгсөн байна.

Манай орон нутагт олон тоогоор илэрч эх орны эдийн засагт чухал үр дүнгээ өгч байгаа алтны орд газруудын эрэл хайгуулын ажлыг амжилттай хийж, зах зээлийн үед эх орныхоо эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолоо өгч байгаа орд газрын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан төрийн шагналт геологич С.Цэрэн-Очир, В.Довжид, Д.Гунгааням, геологич Д.Баадай, Э.Болд, Б.Алтан-Очир, Н.Ням нарын олон арван геологичид ажиллаж байна (зураг 3). Өнгөт, ховор, үнэт металлын ордуудын эрэл хайгуул судалгааны ажилд идэвхитэй оролцож ажилласан С.Сэлэмбаатар, Д.Пунцаглэлэг, Д.Доржготов, Д.Гарамжав, Р.Баатар, Ш.Батжаргал, Д.Даваасамбуу, М.Дамдинбат, Г.Дэжидмаа, барилгын материалын хайгуулын судалгаанд олон жил үр бүтээлтэй ажилласан геологич Б.Бэгзсүрэн, Л.Борис, П.Шаандар, С.Алтангэрэл, Р.Бүүвэйбаатар, Монголын нүүрсний ордын эрэл хайгуулын судалгаанд олон жил үр бүтээлтэй ажилласан Аж Үйлдвэрийн гавъяат ажилтан Л.Мөнхтоогоо, геологич Д.Дашцэрэн, А.Дамиран, С.Жагар, Ч.Чимэддорж, М.Сэдрагчаа Газрын тосны хайгуулын судалгаанд

Д.Пүрэвдорж, Д.Жанчив нарын олон геологичид эх орныхоо түлш эрчим хүчний эх үүсвэр, шатах ашигт малтмалын геологийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсныг тэмдэглэхэд гаатай байна. Давсны орд газрын хайгуулын судалгаанд манай ахмад төгсөгч А.Баасанжав, Ж.Сумъяа нарын геологичдийн оруулсан хувь нэмэр, үнэт эрдэнийн чулууны судалгааны ажлыг хийсэн Т.Намсрай, З.Лхангаа, гидрогеологи, рашаан судлалын хайгуулын ажилд ахмад геологич Н.Лхагваа нарын алдрыг тэмдэглэн хэлэхгүйгээр өнгөрөх боломжгүй юм.

Манай сургуулийг төгссөн олон инженерүүд Геологийн Төв лабораторид минералоги, петрографийн инженерээр ажиллаж эрдэс чулуулгийн шинжилгээний ажилд амжилттай ажиллаж, ашигт малтмалын ордыг илрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Үүнд: Ш.Бизъяа, Ш.Ганжидмаа, С.Сүхээ, Д.Баасанбат, Ж.Хоролханд, Л.Бадраа, Г.Янжмаа, Л.Жаргал, Ц.Өлзий-Очир нарын минералогич, петрографич инженерүүдийг дурьдаж болно.

Аль ч үе шатны геологийн судалгааг явуулахад уул ажлыг удирдан зохион байгуулах авъяаслаг удирдагч чухал үүрэгтэйг хэн бүхэн мэдэх билээ. Манай төгсөгчдөөс олон арван жил геологийн үйлдвэрлэлийн ажлыг удирдаж, үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад геологичид олон байдаг. Геологийн экспедиц, удирдах газрын ажлыг чадамгай удирдаж, тухайн үеийн улсын төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь чанар сайтай хэрэгжүүлж байсан авъяаслаг удирдагч С.Сономцэвээн, Ж.Жамбал, Ч.Хуажин, Г.Болд, Б.Бэгзсүрэн, Ц.Пүрэвцэрэн, Ц.Рэнчиндорж, Б.Гүрлхаажав, С.Цэрэн-Очир, С.Должин, Ш.Баасандорж, Д.Пүрэвдорж, С.Энхцаг, Б.Батжаргал, Д.Чалхаажав олон жил экспедиц, удирдах газрын ерөнхий инженерээр ажиллаж, үйлдвэрлэлийн ажлыг гардан

удирдаж байсан Б.Дашцэрэн, Б.Гандулам, Т.Гансүх, Х.Далилхан, С.Цэвээннамжил, З.Гансүх, Л.Борис, Д.Ванчиндорж, П.Шаандар, Т.Намсрай, Д.Жагварал, Т.Сэнгэдорж, Д.Чагнаадорж, Л.Базарсад, Ж.Сандуйжав нарын олон арван ахмад төгсөгч авъяаслаг удирдагчид манай төгсөгчдийн дундаас төрсөн юм (зураг 4).

Манай төгсөгчдийн дотроос эрдэм номын ажлыг шамдан хийж, эрдмийн зэрэг хамгаалж, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад олон жил идэвхи зүтгэлтэй ажиллаж, эрдмийн зэрэг хамгаалсан 26 эрдэмтэн геологичид эрдэм номын судалгаа хийж, залуу хойч үеэ бэлтгэх ажилд идэвхитэй ажиллаж байгаа Ч.Ээбум, Я.Болд, Ж.Ган-Очир, Д.Чулуун, Ш.Батжаргал, С.Дандар, А.Пэрлээ, Ж.Бадамгарав, Г.Дэжидмаа, Г.Баларч нарын олон авъяаслаг эрдэмтэд байна (зураг 3).

Яамны 1-р орлогч сайдаар ажиллаж байсан А.Баасанжав, Д.Санжаадорж, аймгийн засаг даргаар ажиллаж байгаа Н.Ягаан нарын төгсөгчид төрийн удирдах дээд байгууллагуудад амжилттай ажиллаж байна (зураг 4).

Манай ахмад төгсөгчдийн олон жилийн хөдөлмөрийн үр дүнгээр монгол орны нутагт хийгдсэн 1:1 000 000, 1:200 000, 1:50 000 масштабын геологийн зураглалын ажлуудыг олон мянган километр талбайд хийж, ашигт малтмалын орд газруудыг олноор илрүүлэн олж, түүний хайгуулын шатны ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд манай улсын томоохон орд газруудын нөөц тогтоогдож, ашиглагдаж байна. Үүнд Эрдэнэтийн овоо, Цагаан суварга, Оюут, Хүнгүйтийн зэс молибдений орд, Бага газрын чулуу, Жанчивлан, Баянмод, Егүзэр, Онгон-хайрхан, Цагаандаваа зэрэг ховор металлын орд, Цав, Улаан, Төмөртэй зэрэг холимог металлын орд, Асгат, Мөнгөн-Өндөрийн мөнгөний орд, Заамар, Баянхонгор, Цагаанчулуут, Олон-

Овоот, Өлийн ам, Өлт зэрэг алтны ордууд, Цагаан дэл, Бор-Өндөр, Өргөний хайлуур жоншны орд, Өвдөг худаг, Багануур, Тэвшийн говь, Цайдам зэрэг нүүрсний орд газар, Шаварын царамын үнэт эрдэнийн чулууний орд, Шүдэн уулын давсны орд, Баянгол, Их Тамирын төмрийн орд зэрэг олон арван орд газруудыг нээж ашиглалтанд шилжүүлсэн байна.

Манай төгсөгчдөөс геологийн мэргэжлийн ажлыг хийхийн зэрэгцээ урлаг соёл, биеийн тамир спортын ажлын талаар авъяас билэгээ дайчилан улс эх орныхоо нэр төрийг өндөрт авч яваа төрийн шагналт зохиолч Д.Батбаяр, спортын гавъяат мастер, шатрын олон улсын хэмжээний мастер Л.Мягмарсүрэн, спортын мастер Г.Гунгаабазар, С.Нордод, Н.Төвсанаа, Т.Пүрэвдорж, Т.Рэчиндорж, Д.Дорж, улсын тэргүүний уран сайханч Д.Машлай нарын олон авъяаслаг геологичид байдаг (зураг 3).


Манай салбарыг төгсөгчдөөс удирдах газар, экспедицийн даргаар 66, экспедицийн ерөнхий инженер, ерөнхий геологичоор 56, компанийн захирлаар 45, ангийн даргаар 85, ангийн ерөнхий

геологи, ахлах геологичоор 225 төгсөгч ажиллаж байсанаас харахад (зураг 4) геологийн хээрийн судалгааны хамгийн чухал орон тоон дээр ажиллаж, судалгаа шинжилгээний өдөр тутмын ажлуудыг хийж байсан тодорхой нь харагдаж байна (Эдгээр ажиллаж байсан орон тоог он оноор гаргаж 5 жилээр бүлэгчлэн 5-10-р зургуудад харууллаа).

Үүнээс харахад эхний жилүүдэд төгссөн ахмад төгсөгчид геологи хайгуулын ажлын удирдах албан тушаалуудад түлхүү ажиллаж байсан нь харагдаж байна.

Эх орондоо геологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсэний түүхт 40 жилийн ойн энэ баярын өдрийг тохиолдуулан, МУИС-ийн геологийн салбар байгуулагдсан анхны өдрөөс эхлэн геологчдийг бэлтгэх ажилд гар бие оролцон ажиллаж байсан ахмад болон одоо ажиллаж байгаа нийт эрдэмтэн багш нар, геологийн салбарыг төгсөж МУИС-ийн нэрээр овоглон эх орныхоо эрдэс баялагийн судалгаанд гарамгай амжилт гарган ажиллаж байсан, ажиллаж байгаа нийт төгсөгч геологич нөхөддөө баяр хүргэж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.


ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ЭРДЭМТЭД



Зураг 1.

■ Академич ■ Профессор ■ Доктор (Sc) ▨ Дэд профессор □ Доктор (Ph)


ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ЭРДЭМТЭД СУРГАЛТАНД



Зураг 2.


■ Академич ■ Профессор ■ Доктор (Sc) ▨ Дэд профессор □ Доктор (Ph)

МАНАЙ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 3.


■ Профессор ■ Дэд профессор
 □ Доктор (Ph) ▨ Магистр
 ■ Гавъяат ажилтан ■ Төрийн шагналтан
 ■ Спортын мастер ■ Сургуулиа онцсайн төгсөгч



Зураг 4.

□ 1-р орлогч сайд ■ Салбарын тэргүүний ажилтан
 ■ Удирдах газар, экспедицийн дарга ■ Экспедицийн ерөнхий инженер
 ■ Компанийн захирал ■ Ангийн дарга
 □ Ангийн ерөнхий геологи, ахлах геологи


1963-1970 ОНЫ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 5.

- Удирдах газар, экспедицийн дарга
- Экспедицийн ерөнхий инженер
- Компанийн захирал
- Ангийн дарга
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад


1971-1975 ОНЫ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 6.

- Удирдах газар, экспедицийн дарга
- Экспедицийн ерөнхий инженер
- Компанийн захирал
- Ангийн дарга
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад


1976-1980 ОНЫ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 7.

- Удирдах газар, экспедицийн дарга
- Экспедицийн ерөнхий инженер
- Компанийн захирал
- Ангийн дарга
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад


1981-1985 ОНЫ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 8.

- Удирдах газар, экспедицийн дарга
- Экспедицийн ерөнхий инженер
- Компанийн захирал
- Ангийн дарга
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад


1986-1990 ОНЫ ТӨГСӨГЧДӨӨС



Зураг 9.

- Удирдах газар, экспедицийн дарга
- Экспедицийн ерөнхий инженер
- Компанийн захирал
- Ангийн дарга
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад

1991 ОНООС ОДООГ ХҮРТЭЛ



Зураг 10.

- Компанийн захирал
- Ангийн ерөнхий геологи, ахлах геологи
- Бусад